

**МОНГОЛ УЛСЫН ЕРӨНХИЙ АУДИТОРЫН АЛБАН ТУШААЛД
НЭР ДЭВШИГЧ САНДАГИЙН МАГНАЙСҮРЭНТЭЙ ХИЙСЭН НЭР
ДЭВШИГЧИЙН СОНСГОЛЫН ТАЙЛАН**

Нэр дэвшигчийн танилцуулга

1	Эцэг/эхийн нэр: Сандаг Нэр: Магнайсүрэн Нэр дэвшүүлсэн: Улсын Их Хурлын дарга
2	Нэр дэвших хүсэлт гаргасан албан тушаал: Монгол Улсын Ерөнхий аудитор Сонсгал, түүний үе шат, явуулсан ажиллагааны танилцуулга:

Төрийн аудитын тухай хуулийн 28 дугаар зүйлийн 28.1 дэх хэсэг, Монгол Улсын Их Хурлын хяналт шалгалтын тухай хуулийн 30 дугаар зүйлийн 30.1.1 дэх заалтад Монгол Улсын Ерөнхий аудиторыг Улсын Их Хурлын даргаас санал болгосноор нэр дэвшигчийн сонсгал хийж зургаан жилийн хугацаагаар томилохоор заасны дагуу Улсын Их Хурлын даргаас Монгол Улсын Ерөнхий аудиторт Сандагийн Магнайсүрэнг санал болгон Улсын Их Хуралд ирүүлсэн.

Төсвийн байнгын хороо Монгол Улсын Их Хурлын чуулганы хуралдааны дэгийн тухай хууль, Монгол Улсын Их Хурлын хяналт шалгалтын тухай хууль, Нийтийн сонсгалын тухай хуульд заасан үндэслэл, журам, дэгийг баримтлан Монгол Улсын Ерөнхий аудиторын албан тушаалд нэр дэвшигчтэй хийх томилгооны сонсголыг зохион байгуулахтай холбогдуулан дараах ажиллагааг явуулсан болно.

1.Монгол Улсын Их Хурлын чуулганы хуралдааны дэгийн тухай хуулийн 130, 131 дүгээр зүйлд заасны дагуу Төсвийн байнгын хорооны 2025 оны 04 дүгээр сарын 23-ны өдрийн 08 дугаар тогтоолоор нэр дэвшигчийн сонсголыг 2025 оны 05 дугаар сарын 07-ны өдөр зохион байгуулахаар товлож, оролцогч болон нэр дэвшигчээс асуух асуулт, нэр дэвшигчийн талаарх саналыг 14 хоногийн хугацаанд хүлээн авахаар parliament.mn, ulsturch.mn, zuv.mn, mass TV гэсэн мэдээллийн хэрэгслүүдээр олон нийтэд хүргэсэн бөгөөд 6 оролцогч, 2 ажиглагч нэр дэвшигчийн сонсголд оролцохоор бүртгүүлсэн.

2.Төсвийн байнгын хороо 2025 оны 05 дугаар сарын 07-ны өдрийн 09:00 цагаас Монгол Улсын Их Хурлын чуулганы хуралдааны дэгийн тухай хуулийн 132 дугаар зүйлд заасан дэгийг баримтлан Монгол Улсын Ерөнхий аудиторын албан тушаалд нэр дэвшигчийн сонсголыг явуулсан бөгөөд Монгол Улсын Их Хурлын чуулганы хуралдааны дэгийн тухай хуулийн 7 дугаар зүйлийн 7.1 дэх хэсэгт заасны дагуу Байнгын хорооны гишүүдийн олонх хүрэлцэн ирснээр ирц бүрдэж, Улсын Их Хурлын гишүүн Г.Дамдиням нэр дэвшигчийн сонсголыг даргалсан. Нэр дэвшигчийн сонсголд Улсын Их Хурлын гишүүн Т.Аубакир, Д.Батбаяр, Р.Батболд, Ж.Батжаргал, Д.Батлут, Ж.Баясгалан, Х.Болормаа, Х.Булгантуяа, Г.Ганбаатар, П.Ганзориг, Х.Ганхуяг, Ц.Даваасүрэн, Г.Дамдиням, Б.Заяабал, З.Мэндсайхан, Д.Пүрэвдаваа, Б.Түвшин, Г.Тэмүүлэн, Дав.Цогтбаатар, нэр дэвшигч С.Магнайсүрэн, бүртгэлийн хуудсаар хүсэлтээ ирүүлсэн Т.Амарзаяа, Ж.Батболд, Ж.Сайнзаяа, З.Энхбаяр нарын оролцогч, ажиглагч Д.Оюунбадам оролцсон.

3. Сонсгол даргалагч нэр дэвшигчийн талаар товч танилцуулсны дараа нэр дэвшигч уг албан тушаалд томилогдсон тохиолдолд хийх ажил, нэр дэвшсэн үндэслэл, боловсрол, ажлын туршлага, тухайн албан тушаалд тавих шаардлагыг хангаж байгаа талаар танилцуулж, оролцогчид болон Байнгын хорооны гишүүд нэр дэвшигчээс асуулт асууж, уг хэлсэн.

3.1. Нэр дэвшигч С.Магнайсүрэн тухайн албан тушаалд тавигдах боловсрол, мэргэжил, мэргэшил, туршлага, мэдлэг, ур чадвар, ёс зүй, хуулиар тусгайлан заасан шаардлагыг хангаж байгаа талаарх үндэслэлээ танилцуулахдаа:

Төрийн аудитын байгууллагын үйл ажиллагааг илүү нээлттэй, мэдээлэлд суурилсан, олон улсын шилдэг туршлагыг нутагшуулах замаар төсвийн хөрөнгийг үр ашигтай төлөвлөх, зарцуулах үйл ажиллагаанд хөндлөнгийн, үр дүнтэй хяналтыг бодит ажил хэрэг болгох зорилготой.

Гүйцэтгэлийн аудитын үр нөлөөг сайжруулахын тулд тухайн сэдвээр аудит хийх урьдчилсан судалгааны ажилд зарцуулах хугацааг оновчтой болгон төрийн аудитын стандартын зарчмыг баримтлан улсын хэмжээнд хэрэгжүүлж буй томоохон төсөл, хөтөлбөрийн хэрэгжилт, үйл ажиллагааны эрсдэлийг бууруулсан зардлын хязгаарлалттай, сөрөг үр дагавар багатай, хэрэгжихэд дэмжлэг болохуйц чанартай аудит гүйцэтгэхийг чухалчилна.

Төрийн аудитын байгууллага Монгол Улсын эдийн засаг, нийгмийн хөгжилд тулгарч болохуйц нөхцөл байдлыг үнэлж, сайн туршлага, эрсдэлд суурилсан дүн шинжилгээнд үндэслэн, зохистой арга хэмжээг авч хэрэгжүүлэхэд гүйцэтгэх засаглалд зөвлөн туслах үүргээ хэрэгжүүлэхэд анхаарч ажиллана. Энэ бүхнийг хэрэгжүүлэхэд аудитын технологи, арга зүй, горимыг сайжруулах, мэдээллийн цахим тогтолцоог бий болгох, нөгөө талаас иргэд, олон нийтийн санаа бодлыг төрийн хяналтад нээлттэй хүлээн авахад анхаарлаа хандуулна. Орчин үеийн технологид суурилсан хяналтын тогтолцоог бүрдүүлэх, санхүүгийн хяналт, аудитын үйл ажиллагаанд орчин үеийн дэвшилтэт технологийг нэвтрүүлнэ. Төсвийн гүйлгээ, төрийн худалдан авалтыг цаг хугацаанд нь хянах автомат хяналтын системийг хөгжүүлж, зөрчлийг эрт илрүүлэх, таслан зогсоо боломжийг бүрдүүлж, эрсдэлээс урьдчилан сэргийлж ажиллахыг эрхэмлэнэ гэсэн.

3.2. Нэр дэвшигчийн сонсголд оролцогч “Монголын Залуучуудын эвсэл” ТББ-ийн төлөөлөл Т.Амарзаяа “Сэлбэ сэргэлт” төсөлд хяналт тавих боломжтой эсэх, мөн төрийн аудитын байгууллагын хараат бус байдлыг хэрхэн сайжруулах талаар, “Үнэн хатамж” ТББ-ийн төлөөлөл Ж.Сайнзаяа аудитын төрөл болон гүйцэтгэсэн аудитын чанарын талаар, мөн төсвийн төсөлд өгсөн аудитын зөвлөмж, дүгнэлтийг хэрэгжүүлэх хүрээнд авч хэрэгжүүлэх арга хэмжээний талаар, мөн иргэн, иргэний нийгмийн байгууллагатай хэрхэн хамтарч ажиллах болон аудитын үйл ажиллагааны ил тод байдлыг хангах талаар нэр дэвшигчээс асуулт асууж, хариулт авсан.

3.3. Нэр дэвшигчийн танилцуулгатай холбогдуулан:

Улсын Их Хурлын гишүүн Д.Пүрэвдаваа: Ерөнхий аудитороор томилогдсон тохиолдолд төрийн аудитын байгууллагын хараат бус байдлыг хангах, аудитын тайлангаа Улсын Их Хуралд хүргүүлэхээс гадна олон нийтийг хэрхэн мэдээллээр хангаж ажиллах талаар;

Улсын Их Хурлын гишүүн Т.Аубакир: Туршлагатай төрийн албан хаагч нэр дэвшиж байгаа тул дэмжиж байгаа бөгөөд цаашид эдийн засаг, нийгмийн харилцаатай уялдуулан нийцлийн аудитыг хийхэд хэрхэн үр дүнтэй ажиллах талаар;

Улсын Их Хурлын гишүүн Р.Батболд: Төрийн аудитын байгууллага гадаад зээл, тусlamжийн хөрөнгөөр санхүүжиж байгаа төслүүдийн ашиглалт, зарцуулалтад хэрхэн аудит хийх талаар;

Улсын Их Хурлын гишүүн Х.Ганхуяг: Засгийн газрын тусгай сан, төрийн өмчitт компаниудад гүйцэтгэсэн аудитын дүгнэлт, зөвлөмжийн хэрэгжилтийг хангуулах, хэрэгжүүлээгүй иргэн, хуулийн этгээдэд хариуцлага хүлээлгэх хууль, эрх зүйн орчныг боловсронгуй болгохтой холбоотой баримтлах бодлогын талаар;

Улсын Их Хурлын гишүүн Б.Түвшин: Төрийн аудитын байгууллагын үйл ажиллагаанд нягтлан бodoх бүртгэлийн олон улсын аудитын стандартыг хэрхэн баримталж ажиллах талаар;

Улсын Их Хурлын гишүүн Ж.Батжаргал: Монгол Улсын Ерөнхий аудитороор төрийн албаны туршлагатай, бэлтгэгдсэн төрийн албан хаагч нэр дэвшиж байгаа тул дэмжиж байгаагаа илэрхийлээд, төрийн аудитын байгууллага нь мэргэжлийн байгууллагуудтай хэрхэн хамтран ажиллах талаар, мөн гадаад зээл, тусlamжийн хөрөнгөөр хэрэгжүүлж байгаа төсөл, арга хэмжээнд аудит хийхэд эрх шинэчлэл хийх бодлогын талаар, хөндлөнгийн аудитыг олон улсын түвшинд хүлээн зөвшөөрөгдөх байдалд төрийн аудитын байгууллагаас хэрэгжүүлэх бодлогын талаар, төрийн аудитын байгууллагын боловсон хүчинийг тогтвортой ажиллуулж, аудиторууд болон төсвийн ерөнхийлөн захирагчид болон ерөнхий нягтлан бодогчийн мэргэжил, ур, чадварыг дээшлүүлэхэд хэрхэн анхаарах талаар;

Улсын Их Хурлын гишүүн Д.Батбаяр: Төсөвт байгууллагуудын санхүүгийн байдалд иргэдийн итгэх итгэлийг нэмэгдүүлэх, хяналтыг хэрэгжүүлэхэд авах арга хэмжээний талаар, аудитын зөвлөмж, дүгнэлтийг хэрэгжүүлэх хүрээнд хяналт, хариуцлагыг хэрэгжүүлэхэд чиглэсэн арга хэмжээний талаар;

Улсын Их Хурлын гишүүн Б.Заяабал: Нэр дэвшигчийг дэмжиж байгаагаа илэрхийлээд, төсвийн шууд захирагчаар ажиллах хугацаандаа аудитын ямар дүгнэлт, зөвлөмж авч, түүнийгээ хэрхэн биелүүлж байсан талаар болон эдгээр аудитын зөвлөмжүүд оновчтой байсан эсэх, Засгийн газрын агентлагууд аж ахуйн үйл ажиллагагаа түлхүү явуулж байгаа тул тухайн салбарын бодлогыг тодорхойлоход шаардлагатай тооцоо судалгааг хийж түүнийг хэрэгжүүлэх үндсэн чиг үүргийн хүрээнд ажиллахад анхаарах болон Оюу толгойн гэрээний талаарх байр суурийг тодруулж, Төсвийн байнгын хорооны баталсан 2025 онд гүйцэтгэх аудитын сэдэвт өөрчлөлт оруулах шаардлагатай эсэх талаар, нийцлийн болон гүйцэтгэлийн аудит хийхэд олон нийт, нийгмийн хэрэгцээг харгалзах, цаашид Улсын Их Хуралтай

нээлттэй хамтран ажиллаж аудитын тайлангийн хамт шаардлагатай шийдвэрийн төслийг боловсруулан хэлэлцүүлэх, олон улсын аудитын байгууллагын туршлага, бүтцийг судалж ажиллах, гэрээгээр хамтран ажилладаг аудитын байгууллагыг сонгох, үйл ажиллагаа болон ажлын чанар, аудитын байгууллагыг цахимжуулах зэрэгт анхаарах, аудитын байгууллагын үйл ажиллагааны хандлага, ёс зүйн асуудал, төрийн аудитын байгууллагад үүрэг хүлээлгэсэн зохицуулалтыг зөвхөн Төрийн аудитын тухай хуулиар зохицуулах шаардлагатай талаар;

Улсын Их Хурлын гишүүн Ж.Баясгалан: Төрийн өмчит компаниудын үйл ажиллагаа болон нийтийн өмчийн ашиглалттай холбоотой асуудлыг сайжруулахад баримталж ажиллах бодлогын талаар;

Улсын Их Хурлын гишүүн З.Мэндсайхан: Нэр дэвшигчийг дэмжиж байгаагаа илэрхийлээд төрийн албаны бүтэц, зохион байгуулалтыг оновчтой болгох, мөн гүйцэтгэл, нийцлийн аудитын дүгнэлт, зөвлөмжийг хэрхэн сайжруулах, Засгийн газрын тусгай сангудын үйл ажиллагааны талаар, мөн төрөөс баримтлах урт, дунд хугацааны бодлогын баримт бичгүүдэд нийцлийн аудит хийж дүгнэлт гаргах талаар;

Улсын Их Хурлын гишүүн Г.Ганбаатар: Аудитын байгууллагын удирдлагыг парламент дахь цөөнхөөс сонгодог олон улсын жишиг байгааг анхаарч, удирдлага нь санхүүгийн мэргэжилтэй хүн байх нь зүйтэй талаар, цаашид төрийн албаны бүтэц давхардалгүй байх, цомхон хүний нөөцийг бүрдүүлэх байдлаар төсвийн урсгал зардлыг бууруулах, төрийн аудитын дүгнэлт, зөвлөмжийг үндэслэн хариуцлага хүлээлгэдэг байх зарчмыг хэрхэн хэрэгжүүлж ажиллах талаар;

Улсын Их Хурлын гишүүн Д.Батлут: Төрийн аудитын байгууллагын үйл ажиллагаанд цахимжуулалт, хиймэл оюун ухаан, дэвшилтэт техник, технологийг нэвтрүүлэх байдлаар хараат бус, бие даасан байдлаа хангахад анхаарах, хөдөө аж ахуйн салбарын бүтээгдэхүүний үнийн өсөлтийг төрийн бодлогоор зохицуулах хүрээнд аудитын байгууллага хэрхэн уялдаа холбоотой ажиллах, аудитын дүгнэлт, зөвлөмжийн дагуу хариуцлага тооцох, биелэлтийг хангуулахад анхаарах, төрийн аудитын байгууллага Улсын Их Хуралтай хэрхэн хамтран ажиллах талаар асуулт асууж, хариулт авсан болно.

3.4. Байнгын хорооны гишүүн, оролцогч нэр дэвшигчээс асуулт асууж, хариулт авч дууссаны дараа “Үнэн хатамж” ТББ-ийн төлөөлөл Ж.Сайнзаяа аудитын дүгнэлт, зөвлөмжийг үнэн зөв хийхэд анхаарч, хараат бусаар ажиллах, “Монголын Залуучуудын эвсэл” ТББ-ийн төлөөлөл Т.Амарзаяа иргэдийн мэдэх эрхийг эдлүүлж нэр дэвшигчийн сонсгол зохион байгуулж байгаад талархал илэрхийлээд, хөндлөнгийн аудит хийх чиг үүргээ хэрэгжүүлэхэд анхаарах, үндэсний хороодын хэрэгжүүлж байгаа үйл ажиллагаанд анхаарах талаар уг хэлсэн болно.


3 Сонсголын үйл явцыг нэгтгэн дүгнэх нь:

Монгол Улсын Их Хурлын даргаас санал болгосон Монгол Улсын Ерөнхий аудиторын албан тушаалд нэр дэвшигчийн сонсголыг Монгол Улсын Их Хурлын чуулганы хуралдааны дэгийн тухай хууль, Монгол Улын Их Хурлын хяналт шалгалтын тухай хууль, Нийтийн сонсголын тухай хуульд заасны дагуу Төсвийн байнгын хороо нэр дэвшигчийн сонсголыг 2025 оны 05 дугаар сарын 07-ны өдөр

	<p>Төрийн ордны “Үндсэн хууль” танхимд зохион байгуулж, сонсголд Улсын Их Хурлын 19 гишүүн, нэр дэвшигч, 4 оролцогч, 1 ажиглагч оролцлоо.</p> <p>Нэр дэвшигчийн сонсголын үеэр оролцогч Т.Амарзаяа, Ж.Сайнзаяа, Төсвийн байнгын хорооны гишүүн Д.Пүрэвдаваа, Т.Аубакир, Р.Батболд, Х.Ганхуяг, Б.Түвшин, Ж.Батжаргал, Д.Батбаяр, Б.Заябал, Ж.Баясгалан, З.Мэндсайхан, Г.Ганбаатар, Д.Батлут нар нэр дэвшигчээс талаар асуулт асууж, харилт авсан болно.</p> <p>Монгол Улсын Их Хурлын чуулганы хуралдааны дэгийн тухай хуулийн 133 дугаа зүйлийн 133.1 дэх хэсэгт заасны дагуу мөн өдрийн 11.50 цагт сонсголд оролцсон гишүүд хаалттай хуралдаж, хуралдаанд оролцсон гишүүдийн олонхын саналаар сонсголын тайланг гаргасан.</p>
4	<p>Хаалттай хурлын тайлан</p> <p>Нэр дэвшигчийн сонсголд оролцсон гишүүд хаалттай хуралдаж, нэр дэвшигч Сандагийн Магнайсүрэнгийн ирүүлсэн баримт болон сонсголын үр дүнд үндэслэн Монгол Улсын Ерөнхий аудиторын албан тушаалд тавигдах шаардлагыг хангасан гэж хуралдаанд оролцсон гишүүдийн олонх үзсэн болно.</p>

СОНСГОЛ ДАРГАЛАГЧ:

**МОНГОЛ УЛСЫН ИХ
ХУРЛЫН ГИШҮҮН**



Г.ДАМДИННЯМ